

# The Defacto Gazette

МЭДЭЭЛНЭ

ЗОРИГЖУУЛНА

МЭДЭЛЖҮҮЛНЭ

Пүрэв, 2020.02.20, №07 (136)

УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ, БИЕ ДААСАН,  
УЛС ТӨРИЙН НАМААС ХАРААТ БУС, ДОЛОО ХОНОГ ТУТМЫН ГЛОБАЛ СОНИН

www.jargaldefacto.com

WEEKLY



ДеФакто **НИЙТЛЭЛ**

№516

Д.Жаргалсайхан

Эдийн засагч, нийтлэлч

## ОРОН СУУЦНЫ ОНЦГОЙ НЭГЭН ШИЙДЭЛ



©DefactoDesigner

ДеФакто **ТОЙМ**

### ➤ ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛИЙН ГЭРЧИЛГЭЭГ ХЭРХЭН АШИГЛАХ ВЭ?

Олон Улсын Валютын Сангийн дарга Кристилина Иванова Георгиева 2-р сарын 12-нд “COVID-19 нь дэлхийн эдийн засагт V хэлбэрээр нөлөөлөх буюу огцом унаад эрчимтэй сэргэнэ” гэдгийг мэдээлсэн.

### ➤ МОНГОЛ УЛС 2021 ОНД PISA СУДАЛГААНД ХАМРАГДАНА

Боловсролын зорилго бол оддыг төрүүлэх биш, нийгмийн тэгш бус байдлыг багасгах явдал гэж Финланд улс үзэж байна.

### ➤ БОГД УУЛАНД ГАЗРЫН МАРГААН ТАСРАХГҮЙ БАЙНА


V НҮҮРТ

Монгол Улсын 3.2 сая хүн амын тал нь Улаанбаатар хотод, нийслэлийн иргэдийн тал нь гэр хороололд оршин сууж байна. Дэлхийн 17 дахь том газар нутагтай манай улсын нийслэлд хүн нь, зам дээр машин нь багтахаа больж, хот маань агаар, хөрс, орчны бохирдолдоо живсээр удаж байна.

Энэ бүх асуудлыг шийдэх зангилаа нь хотын бүсчлэл, төлөвлөлт, орон сууц гэж ярьсаар байгаа ч, үр дүн бага байна. Энэ өвөл сайжруулсан түлшээр агаарын бохирдлыг бага зэрэг бууруулсан ч, хөрс, орчны бохирдол, цэвэр усны асуудлаа шийдэж чадахгүй байна. Хамгийн гол, урт хугацааны шийдэл бол гэр хорооллыг орон сууцжуулах гэдэгтэй хүн бүр санал нийлж, олон төсөл хэрэгжүүлж ирсэн ч гэсэн, гэр хороолол улам тэлсээр.


Гэр хороололд амьдарч буй 840 мянган иргэдийн 250 мянга нь орон сууцны зээлд хамрагдах хүсэлт гаргасан ч, тэдний 15 хувь нь зээлийн шаардлага хангахгүй байна. Нийлүүлэлт талаас нь харвал 2020 оны 1-р сарын байдлаар Улаанбаатар хотын хэмжээнд 20 мянган айлын орон сууц борлогдоогүй, эзэнгүй хонож байна.

Зураг 1: Улаанбаатар хотод шинээр ашиглалтанд орсон орон сууцны тоо




- ▶ Орон сууцны нийлүүлэлт (Зураг 1) өссөн ч, иргэдийн худалдан авах чадвар муу байна. Нөгөө талаас орон сууцны нийлүүлэлт өсөөд байхад, үнэ нь буурахгүй (Зураг 2) байгаа нь анхаарал татаж байна.

**Зураг 2: Улаанбаатар хотын шинэ орон сууцны 1 м2 талбайн дундаж үнэ (1.350.000 төгрөг)**



Өрхийн орон сууц худалдан авах чадварыг сарын орлогынхоо 30 хувийг орон сууцны зардалд зарцуулах боломжтой эсэхээр тооцдог. Хүн амын 45 хувь нь тийм чадваргүй (Зураг 3) болох нь харагдаж байна.

**Зураг 3: МУ-ын өрхийн орлогын бүлэг, сараар**



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо, 2019

Харин орон сууцны үнэ буурахгүй байгаа шалтгаанд зээлийн хүү өндөр, төгрөгийн ханшны уналт, банкууд өөрсдөө орон сууц олноор эзэмших болсон, барилгын өртөг нэмэгдсэн, газрын болон бусад зөвшөөрөлтэй холбоотой авлига буурахгүй байгаа зэрэг олон хүчин зүйл орж байна. ▶▶

**СИНГАПУРЫН ШИЙДЭЛ**

▶ Жаран жилийн туршид хэрэгжүүлсэн ухаалаг бодлогын үр дүнд Сингапур улс иргэдийнхээ орон сууцны асуудлыг аль хэдийн бүрэн шийджээ. Өнөөдөр Сингапурын иргэдийн 80 хувь нь нийтийн орон сууцанд амьдарч, тэдний 90 хувь нь орон сууцаа өмчилж авсан ажээ. Орон сууц хөгжлийн зөвлөл (HDB) жаран жилийн өмнөөс нийтийн орон сууц барьж эхэлжээ. Тэдний орон сууц нь хувийн хэвшлийнхээс 20-30 хувиар хямд болдог. Айл өрхүүд өөрийн орлого, хэрэгцээндээ нийцсэн орон сууцыг төрөл бүрийн хөтөлбөрөөр дамжуулан авдаг. Жишээ нь тэтгэврийн сангаас өөрийн нэрийн дансаараа зээл авч, урьдчилгаа төлбөргүйгээр орон сууцанд орж болно. Иргэд тэтгэврийн сандаа цалингаасаа сар бүр

20 хувийг, ажил олгогч нь 17 хувийг хуримтлуулна. Анх удаа, шинэ орон сууцанд орж буй өрхөд орлогоос нь хамаараад 80,000 хүртэл ам.доллар, хуучин орон сууцанд бол 120,000 хүртэлх ам.долларын тэтгэмж олгоно. Тодорхой хугацааны дараа тэр орон сууцаа өмчилж авч болно. Харин гэрлээгүй бол 35 нас хүртлээ өмчлөх эрхгүй, зөвхөн түрээсээр амьдарч болно.

Нийтийн орон сууцыг хувийн өмчлөлд авсан бол эхний таван жил зарах эрхгүй. Өндөр орлоготой өрх бага талбайтай орон сууц худалдан авах боломжгүй. Хэт өндөр орлоготой бол төрөөс барьдаг, нийтийн орон сууц авах ч эрхгүй, хувийн хөрөнгөөр баригдсан, өндөр үнэтэй орон сууц худалдаж авахаас өөр сонголтгүй ажээ.

**МОНГОЛЫН ШИЙДЭЛ**

Нийслэлийн орон сууцны корпораци буюу НОСК-аас орлогод нийцсэн (affordable) орон сууцны хөтөлбөр эхлүүлжээ. Баянхошуу, Шархад гэх мэт гэр хорооллуудад газрыг чөлөөлөх байдлаар, мөн орон нутагт Морингийн даваа зэрэг хотоос гаднах долоон байршилд шинэ газар авчээ. Эдгээр байршилд энэ хавраас НОСК-ийн санхүүжилтээр дэд бүтэц барих бөгөөд аж ахуй нэгжүүдэд дээр нь орон сууц барих саналыг тавьж сонгон шалгаруулах ажээ. Сонгохдоо тухайн компани дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг үнэлээд нийт орон сууцны хэдийг үнэ төлбөргүй, хэдийг хямдралтай үнээр НОСК-д өгөх зэрэг шалгуур тавих гэнэ. Харин НОСК авсан байрнуудаа зах зээлийн үнээс хямдаар түрээслүүлэх, түрээслээд өмчлөх хэлбэрээр орлого багатай иргэдэд орон сууцанд орох боломж олгох гэнэ. Энэ маягаар нийт 10 мянган айлыг орлогод нь нийцсэн, ногоон орон сууцтай болгох аж. Үүнээс 1500 нь түрээсийн, 3000-5000 нь түрээслээд өмчлөх орон сууц, үлдсэнийг нь барьсан компаниуд өөрсдөө борлуулна. Энэ төслийг таван

жилийн дотор хэрэгжүүлнэ гэж НОСК-ийн Гүйцэтгэх захирал Б.Сүхбаатар мэдэгдсэн.

Улаанбаатар хотод орлогод нийцсэн орон сууц барихдаа нийлүүлэлт дээр бол сонголтыг нэмэгдүүлэх; санхүүжилт дээр тогтвортой санхүүжилтийн механизмыг бий болгох; хэрэгжүүлэхдээ хууль эрх зүйн орчин, инстүүцийг бий болгох зэрэг гурван урт хугацааны зорилго тавьжээ. Энэ стратегийг хэрэгжүүлэхдээ төр, хувийн хэвшил, түрээслэгчид, орон нутгийн байгууллагууд зэрэг холбогдох бүх талуудын оролцоог бүрэн хангах гэнэ. Шаардлагатай санхүүжилтийг олон улсын байгууллагуудаас хөнгөлөлттэй, нэн хөнгөлөлттэй урт хугацааны зээлээр хийх юм байна. Жишээ нь, Азийн Хөгжлийн Банкнаас 80 сая, Ногоон хөгжлийн сангаас 145 сая ам.доллар аваад эхлэж байна. НОСК хямд үнэтэй бүх байрны төлбөрийг шууд төлж, мөн 70 хувиас дээш гүйцэтгэлтэй бол тухайн барилгын компанид зээлийн баталгаа гаргаж өгөх ажээ.

**НОСК-ИЙН ТӨСЛҮҮД ҮНЭХЭЭР ХЭРЭГЖИХ ҮҮ?**

Өмнө нь хотын удирдлагууд ил далд авч байсан бүх төлбөр хураамжийг зогсоож, орон сууц барих бүх ажлыг бүх шатанд нь ил тод болгосон учир НОСК-ийн энэ удаагийн төсөл нь Улаанбаатарчуудын орон сууцны асуудлыг шийдэх боломжтой. Гэхдээ хэрэгжих эсэх нь бол асуудалтай. Учир нь 2020 он бол сонгуулийн жил. Сонгуулиар гарч ирсэн Засгийн газар нь өмнөх засгийнхаа ажлыг яаж зогсоож, үгүй хийдгийг иргэд

зөндөө харсан. Тэгэхээр энэ төслийг улс төрөөс хамааруулахгүй хэрэгжүүлэхийн тулд одооноос бүх иргэдийн ойлголт, итгэл шаардлагатай. Түүний тулд төслийн үйл ажиллагааг нээлттэй байлгаж, холбогдох иргэдийг бүрэн оролцуулах нь чухал. Эс бөгөөс бас нэгэн мөрөөдөл цаасан дээр үлдэж, цаг хугацаанд замхарна.

2020.02.19

# The Defacto Gazette

МЭДЭЭЛНЭ | ЗОРИГЖУУЛНА | МЭДЭЛЖҮҮЛНЭ

ДАВАА ГАРАГ БҮР



НЭГ УЛИРЛЫН ҮНЭ  
**30.000₮**

МОНГОЛ ШУУДАН  
**7007-8916**

WWW.MONGOLPOST.MN



## ДеФакто **ТОЙМ**

Ням гараг бүр VTV телевизээр 17 цагт гардаг Дефакто тоймын эмхэтгэл:  
2020.02.16-ны дугаар

Долоо хоног бүрийн тойм, <http://jargaldefacto.com/category/12>

# ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛИЙН ГЭРЧИЛГЭЭГ ХЭРХЭН АШИГЛАХ ВЭ?

Олон Улсын Валютын Сангийн дарга Кристилина Иванова Георгиева 2-р сарын 12-нд “COVID-19 нь дэлхийн эдийн засагт V хэлбэрээр нөлөөлөх буюу огцом унаад эрчимтэй сэргэнэ” гэдгийг мэдээлсэн. 2000 оны эхээр Сарс гарч Хятадын эдийн засагт нөлөөлж байсан нөлөөлөл одоогийнхоос өөр. Учир нь тэр үед Хятадын эдийн засаг олон улсад нөлөөлөх хэмжээний том байгаагүй буюу дэлхийн эдийн засгийн 8 хувь байсан. Харин одоо бол Хятадын эдийн засаг дэлхийн эдийн засгийн 19 хувийг эзэлсэн том эдийн засаг болсон. Ялангуяа Ази тивийн бусад улсын эдийн засаг Хятадын эдийн засгийн динамикаас хамаарч байна.

Хятад улсад гарсан Корона вирусын тархалт намжихгүй улам тэлсээр байгаа. Энэ үед Монгол Улс хамгийн эрсдэлт бүсд тооцогдож байгаа учраас хөл хорио тогтоож, олноор цугларахыг 3-р сарын 30 хүртэл хориглосон байгаа. Энэ нь бизнесүүд, ялангуяа жижиг бизнесүүдэд хүндрэл учруулж, сар тутмын түрээс, зээлийн эргэн төлөлтөө ч хийж чадахгүй байна гэдгийг бизнесийнхэн хэлсээр байгаа.

Талууд хоорондоо гэрээний үүрэг биелүүлэх, биелүүлж байх явцад талуудын хүсэл зориг, хяналтаас гадуур, урьдчилан таамаглах боломжгүй нөхцөл байдал бий болсон тохиолдолд Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас “Force majeure” буюу Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл болон “Hardship” буюу Хүнд нөхцөл байдал-ын баталгаа гаргаж өгдөг. “Баталгаа” гаргуулахыг хүсэгч хувь хүн, аж ахуйн нэгж, байгууллага МҮХАҮТ-д дараах материалыг

бүрдүүлж өгнө. Үүнд:

- Баталгаа гаргуулах тухай хүсэлт
- Гэрээний нотариатаар баталгаажуулсан хуулбар / монгол хэлээр/
- Аж ахуйн нэгж бол улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар
- Тухайн нөхцөл байдлыг нотлох бусад баримт бичиг

Хэдий МҮХАҮТ-ын өгөх “баталгаа” чухал ч гэсэн банкууд Худалдааны Танхимыг өөрийнхөө гишүүдэд гэрчилгээ өгдөг ашиг сонирхлын зөрчилтэй гэж үздэг юм байна. Монголын 180 мянган аж ахуйн нэгжээс 3500 нь л Худалдааны Танхимын гишүүнээр элссэн байдаг.

Компанийн нийгмийн хариуцлага гэдэг зүйл яг ийм үйл явдал болж байгаа үед илүү тод мэдрэгдэх боломж гарч байна. Тухайлбал Хонконгд том групп компаниуд нийгмийн хариуцлагын хүрээнд гээд түрээслэгчдийнхээ түрээсийг 50 хувь хөнгөлж байгаа жишээ гарч байна. Хөнгөлөлт нь хэр хугацаанд үргэлжлэх нь COVID-19-ийн тархалтаас шалтгаална гэсэн байна лээ.

COVID-19-ийн цаг үеийн үйл явдал төсвийн орлогод нөлөөлж эхлэх нь. Тиймээс төсвийн зарлагыг эрс багасгахгүй бол Монгол улс дахиад л өрөнд орно. 2021, 22, 23, 24 онд нийт 2.9 тэрбум долларын бондын өр төлнө.

## МОНГОЛ УЛС 2021 ОНД PISA СУДАЛГААНД ХАМРАГДАНА

Боловсролын зорилго бол оддыг төрүүлэх биш, нийгмийн тэгш бус байдлыг багасгах явдал гэж Финланд улс үзэж байна. 1980-аад онд хийсэн боловсролын шинэтгэл нь сургуулийг хүүхдийн хувьд эрүүл, аюулгүй орчин болгохыг зорьжээ. Энэ улс бүх сурагчдад өдрийн хоол үнэгүй өгч, эрүүл мэндээ хамгаалах, сэтгэл зүйн зөвлөгөө авах, ганцаарчилсан сургалт авах боломжоор хангадаг.

Үр дүнд нь 2000 оноос хойших PISA survey, буюу 15 настай сурагчдын унших, математик, байгалийн ухааны мэдлэг чадварыг харьцуулсан судалгаагаар Финланд улс дэлхийд тэргүүлж эсвэл удаалж ирлээ. Энэ судалгааг Өмнөд Солонгос, Сингапур хоёр бас тэргүүлж өрсөлддөг. Энэ судалгаанд 2021 оноос Монгол улс анх удаагаа орох гэж байгаа гэсэн сайхан мэдээ байна.

Гэхдээ 2019 оны хичээлийн жилийн байдлаар ЕБС-ийн нийт сурагчдын 7 хувь нь, дээд боловсролын нийт оюутны



46 хувь нь хувийн сургуульд суралцаж байна. Ерөнхий боловсролын 803 сургуулиас 160 нь, 34 их сургуулиас 20 нь, 48 дээд сургуулиас 44 нь тус тус хувь хүний хөрөнгө. Хувийн, дунд сургуулийн нэг хүүхдийн нэг жилийн төлбөр 2019 оны байдлаар 1-58 сая төгрөгийн хооронд, дунджаар 8 сая төгрөг болжээ. Нэг анги нь төрийн сургуулиас хоёроос гурав дахин цөөн хүүхэдтэй, багш нарын цалин хоёроос арав дахин өндөр, гадаад хэлийг төрөлх хэлтэй гадаад багш зааж, сургах

нөхцөл нь өндөр хөгжилтэй оронтой өрсөлдөхүйц болсон учир хувийн сургуулийн сургалтын чанар сайн, төгсөгчдийн дийлэнх нь дэлхийн нэр хүндтэй их дээд сургуульд элсэн орж, суралцах боллоо. Энэ мэдээж маш сайн хэрэг. Гэхдээ улсын сургуульд хөрөнгө мөнгө хүрэхгүй байхад өндөр төлбөртэй хувийн сургуульд улсын сургуулийн адил хүүхэд бүрийн тоогоор хувьсах зардал нэмж олгож байгаа нь хачирхалтай. Бусад оронд хэрэв төсвөөс мөнгө хувийн сургуульд олгож байгаа бол төлбөрийн дээд түвшинг тогтоож, хүүхдүүдийг оршин суугаа харьяаллаар нь авахыг шаарддаг. Харин манай улсад төр засгийн удирдлагуудын хүүхэд, ач гуч нар бүгд хувийн сургуульд явдаг, мөн төр засгийн үе үеийн удирдлагын олон хүн өөрсдөө хувийн сургууль байгуулсан учир, улс даяар хүрэлцэхгүй байгаа боловсролын хомс төсвөөс хувийн сургуульд үргэлж олгож ирлээ. Үүний үр дүнд боловсрол нь ашгийн төлөө бизнес болж, нийгэм гэрлийн хурдаар баян,

ядуугийн хоёр туйл руу огцом хуваагдан, түргэн татагдаж байна. Боловсролын ялгаа нь насан туршийн ялгаа болдог. Хүүхдүүдийн хооронд баян ядуугаараа ялгаварлан гадуурхах хандлага ажиглагдах болов. Хувийн сургууль байгуулагдаад нийгмийн ядуурлыг бууруулахгүй, харин ч нийгмийн тэгш бус байдлыг улам дэврээх боллоо.

Мөн 2020 оны элсэлтийн ерөнхий шалгалтын бүртгэл эхэлсэнтэй холбоотойгоор Боловсролын үнэлгээний төвөөс мэдээлэл хийсэн. Энэ үеэр Боловсролын үнэлгээний төвийн хэлтсийн дарга Л.Ганбат “Монголын сурагчдын сурлагын чанарыг илтгэх үндэсний хэмжээний судалгаа хийж байгаагүй. Тиймээс өнөөдөр шууд Монгол Улсын боловсролын чанар сайн эсвэл муу гэж дүгнэж хэлэх боломжгүй” гэснийг тэмдэглэх хэрэгтэй. Боловсролын үнэлгээний төв зөвхөн сурагчдын сурлагын чанарын үнэлгээг анги ангиар нь хийж байсан юм байна.

## БОГД УУЛАНД ГАЗРЫН МАРГААН ТАСРАХГҮЙ БАЙНА



Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018, 2019 оны тушаалаар Богд ууланд 140 гаруй иргэн, аж ахуйн нэгж байгууллагын газар ашиглах эрхийг цуцалсан. Гэсэн ч зарим иргэн, аж ахуйн нэгж, байгууллага уг асуудлаар БОАЖЯ-ыг шүүхэд өгч, шүүхээс тэдний талд шийдвэр гаргаснаар асуудал бүрэн гацаанд ороод байгаа гэдгийг БОАЖЯ-ны Хуулийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Т.Номин-Эрдэнэ хэлж байна. Хамгийн энгийн жишээг л дурдахад нэг эзэнтэй Монголын Үндэсний Их Сурууль нэртэй НҮТББ (нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага), Политехникийн коллеж нэртэй НҮТББ гэгч хуулийн этгээдүүд нэр дээрээ 40

гаруй га газрыг Богдхан ууланд хашчихаад газрын төлбөр төлөхгүй, үйл ажиллагаа явуулахгүй өнөөдрийг хүрсэн. Тусгай хамгаалалттай газар нутагт иргэн, ААН газрыг зөвхөн ашиглах эрхтэйгээр тодорхой хугацаагаар тусгай зөвшөөрөл гаргуулдаг. Гэтэл эдгээр ТББ-ууд өөрийн эзэмшил шиг л аашилдаг. 2017 онд нийтийн эзэмшлийн машины зогсоол барих гэж эдгээр НҮТББ-уудын газраас 3.5 га газрыг улс авах гэж багагүй эсэргүүцэлтэй тулгарч байсан. Энэ газрыг БОАЖ-ын сайд Н.Цэрэнбатын тушаалаар цуцалсан ч шүүхэд хандаж тухайн байгууллага 4 удаа ялалт байгуулсан байдаг юм.

## Улсын бүртгэлийн ерөнхий газраас МУИС-ийн улсын бүртгэлийн мэдээллийг авааг

## Үндсэн мэдээлэл

Регистрийн дугаар	Оноосон нэр	Бүртгэсэн огноо	Хэлбэр	Төрөл	Хувьцаа эзэмшигч, гишүүний тоо	Хуулийн этгээдийн хаяг
9133615	Монголын үндэсний их сургууль	2013.12.26	НҮТББ	Ашгийн төлөө бус	1	Улаанбаатар, Баянгол, 11-р хороо, 3 хороолол, ард аюушийн өргөн чөлөө, Өөрийн байр

## Хувьцаа эзэмшигч, гишүүний мэдээлэл

Д/д	Ангилал	Улсын нэр	Эцэг/эх/-ийн нэр	Нэр	Бүртгэсэн огноо
1	Иргэн	Монгол	Лхагвасүрэн	Мөнхбат	2013.12.26

## Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий албан тушаалтан, эрх барих этгээдийн мэдээлэл

Д/д	Албан тушаал	Улсын нэр	Эцэг/эх/-ийн нэр	Нэр	Бүртгэсэн огноо
1	Удирдах зөвлөлийн дарга	Монгол	Лхагвасүрэн	Мөнхбат	2015.03.11

## Үйл ажиллагааны чиглэлийн мэдээлэл

Д/д	Үйл ажиллагааны код	Үйл ажиллагааны чиглэл	Бүртгэсэн огноо
1	8530	Тусгай зөвшөөрлийн хавсралтад заасан боловсрол олгох сургалт эрхлэх	2015.03.12
2	8530	Тусгай зөвшөөрлийн хавсралтад заасан боловсрол олгох	2015.03.11
3	8530	Тусгай зөвшөөрлийн хавсралтад заасан боловсрол олгох үйл ажиллагаа	2013.12.26

Дээр яригдаж байгаа Монголын Үндэсний Их Сургуулийн тухай өмгөөлөгч, хууль зүйн доктор Д.Уянга “Монголын Үндэсний Их Сургууль гэх хувийн сургууль (МУИС) нь урьд өөр нэртэй байж байгаад 2012 онд энэ нэрийг авсан байна. Энэ сургуулийн лого, нэрийн товчлол нь Монгол Улсын Их Сургуультай (МУИС) их төстэй. Ийнхүү улсын их сургуулийн нэрийг ашиглах замаар “сайн сургууль” гэсэн ойлголтыг иргэдэд төрүүлж, шударга бусаар өрсөлдөөний давуу тал олж авдаг байна. Бүр төрийн сайд нь энэ сургуулийг “дийлэхгүй” байгаагаа учирлаж хэвлэлээр гомдоллосон байх юм” гэж нийтлэлдээ бичсэн байдаг.

Тусгай Хамгаалалттай Газар Нутгийн Тухай Хуулийн 11 дүгээр зүйлийн 11.7 дахь хэсэгт зааснаар Дархан цаазат тусгай хамгаалалттай газар нутагт зөвхөн судалгаа шинжилгээ,

аялагч хүн түр буудаллах, отоглох зориулалтаар л ашиглахыг хуулиар зөвшөөрсөн байдаг. Гэтэл яагаад Байгаль орчин, аялал жуулчлалын яамны удирдлагууд зөвшөөрөл өгөөд байгаа юм бэ? Богд уулын ам болгон Байгаль орчин, аялал жуулчлалын яамны үе үеийн удирдлагуудын авлигын золиос болчихсон. Хүн бүрийн нүдэн дээр ил байгаа Зайсан, Нүхтийн амыг л хар. Одоо тэгтэл Байгаль орчны яам нь өөрөө газар ашиглах зөвшөөрөл өгсөн байгууллага, иргэдээ дийлэхээ больсон буюу тухайн байгууллага, иргэд нь аль хэдийн тухайн газарт үндсэн хөрөнгө босгочихсон учир хөөгөөд явуулж чадахгүй байдалд орчихсон байна. Тиймээс тэдний үндсэн хөрөнгийн үнэлгээнээс нь өндөр татвар авах ёстой. Тэгвэл шударга ёс руу арай дөхнө.

*Дефакто тоймын гол агуулгыг хураангуйлан бэлтгээ Тоймын бүрэн эхийг [jargaldefacto.com](http://jargaldefacto.com) вебсайтаас үзэх боломжтой.*

Та “Дефакто Газет” цахим сонинг тогтмол хүлээн авахыг хүсвэл  
[www.jargaldefacto.com](http://www.jargaldefacto.com) болон [www.defacto.mn](http://www.defacto.mn) вебсайтад өөрийн имейлээ бүртгүүлнэ

## РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ

Ерөнхий эрхлэгч:  
Дамбадаржаагийн Жаргалсайхан

Ерөнхий Редактор:  
Ганбаатарын Жавзмаа

## ГҮЙЦЭТГЭЛИЙН БАГ

Отгонсүрэнгийн Билгүүн  
Адъяагийн Тунгалаг

## ХОЛБОО БАРИХ

✉ [editor1@jargaldefacto.com](mailto:editor1@jargaldefacto.com)

☎ +976 94109342

🌐 [www.defacto.mn](http://www.defacto.mn)